24.5.Ашиглалтын тусгай зөвшөөрлийн хугацааг сунгах тохиолдолд гэрээлэгч дараах баримт бичгийг бүрдүүлэн төрийн захиргааны байгууллагаар дамжуулан төрийн захиргааны төв байгууллагад ирүүлнэ:

24.5.1.ашиглалтын тусгай зөвшөөрлийн хугацааг сунгуулах тухай хүсэлт, үндэслэл;

24.5.2.ашиглалтын тусгай зөвшөөрлийн хугацаанд гүйцэтгэсэн ажлын тайлан;

24.5.3.байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх ажлын тайлан;

24.5.4.тухайн жилд гүйцэтгэх ажлын төлөвлөгөө, төсвийн төсөл.

24.6.Ашиглалтын тусгай зөвшөөрөл олгосноос хойш 90 хоногийн дотор энэ хуулийн 24.4.5-д заасны дагуу ашиглалтын талбайн хилийн хэмжилт хийж, шав тэмдэг тавих ажлыг холбогдох мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлнэ.

24.7.Төрийн захиргааны төв байгууллага ашиглалтын тусгай зөвшөөрөл олгосон болон сунгасан талаар тухайн нутгийн захиргааны байгууллагад мэдэгдэнэ.

## **25 дугаар зүйл.Газрын тосны ашиглалт**

25.1.Гэрээлэгч хайгуулын хугацаа дууссанаас хойш 90 хоногийн дотор ашиглалтын үйл ажиллагаа явуулах эсэх тухай хүсэлт гаргаагүй тохиолдолд бүтээгдэхүүн хуваах гэрээг дуусгавар болгож, тухайн талбайд ашиглалт явуулах этгээдийг энэ хуулийн 20, 26 дугаар зүйлд заасны дагуу нээлттэй сонгон шалгаруулалтаар тодруулна.

25.2.Газрын тосны ашиглалтын хугацаа 25 хүртэл жил

байх бөгөөд гэрээлэгч ашиглалтын хугацааг сунгуулах хүсэлт гаргасан тохиолдолд төрийн захиргааны байгууллага тав хүртэл жилээр хоёр удаа сунгаж болно.

25.3. Уламжлалт бус газрын тосны ашиглалтын хугацаа 30 хүртэл жил байх бөгөөд гэрээлэгч ашиглалтын хугацааг сунгуулах хүсэлт гаргасан тохиолдолд төрийн захиргааны байгууллага нэг удаа тав хүртэл жилээр сунгаж болно.

25.4. Гэрээлэгч бүтээн байгуулалтын ажлыг гүйцэтгэхдээ дэд бүтэц, байгаль орчны асуудлаар холбогдох төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллагаас зохих зөвшөөрөл авна.

25.5. Газрын тосны орд, газрын тосны хуримтлалтай хураагуур нь хоёр ба түүнээс дээш, ашиглалтын талбайн хил заагийг дамнан байршил тохиолдолд гэрээлэгчид нь хамтран ашиглах гэрээ байгуулан ашиглалтын нэгдсэн төлөвлөгөө, төсөв боловсруулж төрийн захиргааны байгууллагаар батлуулна.

25.6. Гэрээлэгч нь энэ хуулийн 25.5-д заасныг хэрэгжүүлэхээс татгалзсан тохиолдолд тухайн газрын тосны хуримтлалтай хураагуурыг хэрхэн ашиглах талаарх шийдвэрийг газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага холбогдох хууль тогтоомж, шинжлэх ухааны аргачлалд үндэслэн шийдвэрлэнэ.

25.7. Гэрээлэгч ашиглалтын тусгай зөвшөөрөл олгосон өдрөөс хойш 60 хоногийн дотор ашиглалтын эхний жилийн төлөвлөгөө, төсвийг төрийн захиргааны байгууллагаар батлуулна.

25.8. Гэрээлэгч ашиглалтын хоёр дахь жилээс эхлэн тухайн жилийн ашиглалтын төлөвлөгөө, төсвийн төслийг хуанлийн өмнөх жил дуусахаас 90 хоногийн өмнө төрийн захиргааны байгууллагад ирүүлнэ.

25.9.Гэрээлэгч баталгаат нөөцөөс ашиглалтын үйл ажиллагааг явуулах бөгөөд энэ хэсэг олборлолтын туршилтад хамаарахгүй.

25.10.Гэрээлэгч газрын тосны ордын нөөцийг ашиглах дэвшилтэт техник, технологийг нэвтрүүлнэ.

## **26 дугаар зүйл.Ашиглалтын талбайд нээлттэй сонгон шалгаруулалт явуулах**

26.1.Дараах тохиолдолд ашиглалтын талбайд нээлттэй сонгон шалгаруулалтыг зарлана:

26.1.1.газрын тосны нөөцийг хүлээн авсан тухай төрийн захиргааны төв байгууллагын шийдвэр гарсны дараа хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь ашиглалтын тусгай зөвшөөрөл авах хүсэлт гаргаагүй;

26.1.2.улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийж, нөөцийг тогтоосон;

26.1.3.өмнөх ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь ашиглалтын үйл ажиллагаа явуулахаас татгалзаж талбайг буцааж өгсөн;

26.1.4.өмнөх ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь хууль тогтоомж зөрчсөний улмаас түүний ашиглалтын тусгай зөвшөөрлийг хүчингүй болгон талбайг буцаан авсан;

26.1.5.ашиглалтын тусгай зөвшөөрлийн хугацаа дуусаж талбайг буцааж авсан;

26.1.6.шүүхийн шийдвэрээр ашиглалтын тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон.

26.2.Энэ хуулийн 26.1-д заасан талбайд энэ хуулийн 8.1.3-т заасан журмын дагуу нээлттэй сонгон шалгаруулалт явуулж, гэрээлэгчийг сонгон шалгаруулна.

26.3.Төрийн захиргааны байгууллага энэ хуулийн 26.2-т заасан сонгон шалгаруулалтын ялагчтай бүтээгдэхүүн хуваах гэрээний төслийг тохиролцож, төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

26.4.Энэ хуулийн 26.2-т заасан хуулийн этгээдтэй энэ хуулийн 17.5, 17.6-д заасны дагуу бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулж, ашиглалтын тусгай зөвшөөрөл олгоно.

## **27 дугаар зүйл.Газрын тосны хэмжилт, үнэ**

27.1.Олборлосон газрын тосны хүргэлтийн цэгийг төрийн захиргааны байгууллага, гэрээлэгч харилцан тохиролцож тогтооно.

27.2.Хүргэлтийн цэгийн байршлын талаар талууд 30 хоногийн дотор тохиролцож чадаагүй бол төрийн захиргааны байгууллага хүргэлтийн цэгийг тогтооно.

27.3.Хүргэлтийн цэг дээр хөндлөнгийн мэргэжлийн байгууллагаар хэмжилт хийлгэнэ.

27.4.Төрийн захиргааны байгууллага хяналтын цэгийг тогтоож болно.

27.5.Төрийн захиргааны байгууллага, гэрээлэгч газрын тосны үнийг олон улсын зах зээл дээр борлуулж байгаа ижил төстэй шинж чанартай газрын тосны үнийг үндэслэн тогтооно.

27.6.Олборлолтын туршилт болон олборлолтын явцад олборлосон газрын тосыг хүргэлт болон хяналтын цэг дээр эрх бүхий байгууллагаар баталгаажуулсан хэмжих төхөөрөмжөөр хэмжинэ.

27.7.Хэмжих төхөөрөмжийн хэвийн үйл ажиллагаа алдагдсан буюу хэмжилт алдаатай хийгдсэн тохиолдолд алдаа гарсан хугацааг хэмжилт алдаатай болсныг мэдсэн өдрөөс өмнө нь хэмжих төхөөрөмжийг хянаж шалгасан

өдрийн хоорондох хугацааны дундах өдрөөс эхлэн тооцно.

27.8.Хэмжих төхөөрөмжийн бүрэн бүтэн байдал, байнгын хэвийн үйл ажиллагааг хангах, хяналт тавих зорилгоор мэргэшсэн, хөндлөнгийн байгууллагыг ажиллуулах ба үүнтэй холбогдон гарах зардал, төлбөрийг гэрээлэгч бүрэн хариуцна.

## **28 дугаар зүйл.Газрын тос хадгалах**

28.1.Олборлосон газрын тосыг дараах байдлаар хадгалж болно:

28.1.1.газрын тос хадгалах байгууламж барьж ашиглах;

28.1.2.тусгай зөвшөөрлөөр олгогдсон талбайд байгалийн байдлаараа оршиж байгаа газрын тосны хураагуурын орон зайл төрийн захиргааны байгууллагаас зөвшөөрөл авч ашиглах.

28.2.Энэ хуулийн 28.1.2-т заасан хураагуурт газрын тосыг юулэх болон буцаан гаргахдаа энэ хууль болон холбогдох дүрэм, журамд заасны дагуу хэмжинэ.

## **29 дүгээр зүйл.Газрын тосыг тээвэрлэх**

29.1.Олборлосон газрын тосыг төмөр зам, тусгай зориулалтын автомашин, эсхүл дамжуулах хоолойгоор тээвэрлэнэ.

29.2.Гэрээлэгч газрын тосыг тусгай зориулалтын автомашинаар тээвэрлэх тохиолдолд холбогдох төрийн захиргааны байгууллагаас баталсан замын төрөл, стандартыг мөрднө.

29.3.Гэрээлэгч ашиглалтын талбайд үйлдвэрлэлийн зориулалт бүхий дамжуулах хоолой барьж болох ба уг дамжуулах хоолой нь гэрээний хугацаанд гэрээлэгчийн өмч байх бөгөөд гэрээний хугацаа дуусгавар болсны дараа энэ хуулийн 39.1-д заасны дагуу шийдвэрлэгдэнэ.

29.4. Гэрээлэгч газрын тосыг борлуулах зориулалт бүхий дамжуулах хоолой барих бол энэ тухай хүсэлтээ төрийн захиргааны төв байгууллагад гаргана.

29.5. Төрийн захиргааны төв байгууллагаэнэхуулийн 29.4-т заасан хүсэлтийг хүлээн авснаас хойш зургаан сарын дотор саналаа Засгийн газарт хүргүүлж, зохих шийдвэр гаргуулна.

**ДОЛООДУГААР БҮЛЭГ**  
**ТӨЛБӨР, ЗАРДАЛ, ӨРТӨГ НӨХӨЛТ, БҮТЭЭГДЭХҮҮН**  
**ХУВААЛТ**

**30 дугаар зүйл. Тусгай зөвшөөрлийн төлбөр,  
түүнийг хуваарилах**

30.1. Гэрээлэгч газрын тосны хайгуулын болон ашиглалтын үед тусгай зөвшөөрлийн төлбөрийг жил бүр төлнө.

30.2. Хайгуулын тусгай зөвшөөрлийн жилийн төлбөр нь гэрээт талбайн нэг хавтгай дөрвөлжин километр тутамд гурван америк доллартай тэнцэх хэмжээний төгрөг байна.

30.3. Хайгуулын хугацааг сунгасан тохиолдолд тусгай зөвшөөрлийн жилийн төлбөр нэг хавтгай дөрвөлжин километр тутамд найман америк доллартай тэнцэх хэмжээний төгрөг байна.

30.4. Ашиглалтын тусгай зөвшөөрлийн жилийн төлбөр нь нэг хавтгай дөрвөлжин километр тутамд 100 америк доллартай тэнцэх хэмжээний төгрөг байна.

30.5. Ашиглалтын хугацааг сунгасан тохиолдолд гэрээт талбайн жилийн төлбөр нэг хавтгай дөрвөлжин километр тутамд 200 америк доллартай тэнцэх хэмжээний төгрөг байна.

30.6.Тусгай зөвшөөрлийн төлбөрийн 10 хувийг тухайн тусгай зөвшөөрлийн талбайг харьяалах сум, дүүргийн төсөвт, 20 хувийг аймаг, нийслэлийн төсөвт, 70 хувийг улсын төсөвт тус тус хуваарилна.

30.7.Тусгай зөвшөөрлийн төлбөрийг тухайн санхүүгийн жил эхэлснээс хойш 30 хоногийн дотор төлнө.

30.8.Тусгай зөвшөөрлийн төлбөрийг энэ хуулийн 30.7-д заасан хугацаанд төлөөгүй бол энэ хуулийн 30.2-30.5-д заасан төлбөрийн гуравны нэгтэй тэнцэх торгуулийг хугацаа хэтрүүлсэн хоног тутамд нэмж тооцон төлнө.

### **31 дүгээр зүйл.Нөөц ашигласны төлбөр, түүнийг хуваарилах**

31.1.Газрын тос, байгалийн хийн нөөц ашигласны төлбөрийн хэмжээ нь олборлосон түүхий тос, байгалийн хийн 5-15 хувь байна.

31.2.Уламжлалт бус газрын тосны нөөц ашигласны төлбөрийн хэмжээ нь 5-10 хувь байна.

31.3.Нөөц ашигласны төлбөрийн 30 хувийг тухайн орон нутгийн хөгжлийн нэгдсэн санд, 70 хувийг улсын төсөвт тус тус төвлөрүүлнэ.

~~31.4.Засгийн газарт нөгдөх түүхий төсны жил бүрийн борлуулалтын орлогын гурван хувийг Газрын тосны салбарыг хөгжүүлэх санд төвлөрүүлнэ.~~

*/Энэ хэсгийг 2015 оны 1 дүгээр сарын 23-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/*

### **32 дугаар зүйл.Өртөг нөхөгдөх зардал, өртөгт газрын тосыг тооцож**

32.1.Газрын тостой холбогдсон үйл ажиллагаа явуулахад шаардагдах бүх зардлыг гэрээлэгч хариуцна.

32.2.Өртөг нөхөгдөх зардлыг төрийн аудитын байгууллагаар баталгаажуулж, бүтээгдэхүүн хуваах гэрээнд заасан өртөгт газрын тосны хувиар нөхнө.

32.3.Өртөгт газрын тосны хэмжээ нь тухайн жилд олборлосон нийт газрын тосноос нөөц ашигласны төлбөрт ногдох газрын тосыг хасаад үлдэх тосны 40 хүртэл хувь байх ба уламжлалт бус газрын тосны хувьд энэ хуульд заасан холбогдох журмын дагуу зохицуулна.

32.4.Бүтээгдэхүүн хуваах гэрээ дуусгавар болох үед өртөг нөхөгдөх зардлаас нөхөгдөөгүй үлдсэн хэсгийг гэрээлэгчид олгохгүй.

32.5.Хайгуулын үеийн олборлолтын туршилтын зардал нь хайгуулын ажлын зардалд хамаарна.

32.6.Өртөг нөхөгдөх зардалд энэ хуулийн 30.2-30.5, 30.8, 31.1-31.2, 34 дүгээр зүйлд заасан төлбөр хамаarahгүй.

32.7.Гэрээлэгчийн тайлагнасан өртөг нөхөгдөх зардал санхүүгийн баримтаар нотлогдоогүй тохиолдолд өртөг нөхөгдөх зардалд тооцогдохгүй.

32.8.Засгийн газар гэрээлэгчийн өртөг нөхөгдөх зардалд хүү төлөхгүй.

### **33 дугаар зүйл.Бүтээгдэхүүн хуваалт**

33.1.Ашигт газрын тосыг Засгийн газар, гэрээлэгчтэй бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу хуваана.

33.2.Ашигт газрын тосны Засгийн газарт ногдох хэмжээг хоногт олборлох газрын тосны хэмжээтэй уялдуулан бүтээгдэхүүн хуваах гэрээнд тодорхойлон заана.

### **34 дүгээр зүйл.Бусад төлбөр,урамшуулал, үйлчилгээний хэлс**

34.1.Гэрээнд гарын үсэг зурсны, олборлолт эхэлсний, олборлолт нэмэгдүүлсний болон сургалтын урамшууллыг энэ хуулийн 17.3-т заасан сонгон шалгаруулалтад захиалагчаас санал болгосон хувь, хэмжээгээр гэрээнд тусгана.

34.2.Гэрээлэгч нь сургалтын болон орон нутаг хөгжүүлэх урамшуулал, төлөөлөгчийн газрын үйл ажиллагааны дэмжлэгээс бусад төлбөрийг улсын төсөвт шилжүүлнэ.

34.3.Сургалтын урамшуулал, төлөөлөгчийн газрын үйл ажиллагааны дэмжлэгийг төрийн захиргааны байгууллагад шилжүүлнэ.

34.4.Орон нутгийг хөгжүүлэх урамшууллыг орон нутгийг хөгжүүлэх санд шилжүүлнэ.

34.5.Хайгуулын талбайн захиалгын үйлчилгээний хэлс 20000 амERIC доллартай тэнцэх хэмжээний төгрөгийг төрийн захиргааны байгууллагын дансанд төвлөрүүлнэ.

34.6.Гэрээлэгч хайгуулын талбайн хэмжээг нэмэгдүүлэхэд 100000 амERIC доллар, ашиглалтын талбайн хэмжээг нэмэгдүүлэхэд 250000 амERIC доллартай тэнцэх хэмжээний төгрөгийг улсын төсөвт төлнө.

34.7.Гэрээлэгч гэрээний эрх, үүргээ шилжүүлэхдээ хайгуулын талбайд нээлт тогтоогдооос өмнө 20000 амERIC доллар, нээлт тогтоогдсоны дараа 50000 амERIC доллартай тэнцэх хэмжээний төгрөгийг улсын төсөвт төлнө.

34.8.Ашиглалтын үед гэрээний эрх, үүргээ шилжүүлбэл 100000 амERIC доллартай тэнцэх хэмжээний төгрөгийг улсын төсөвт төлнө.

## **НАЙМДУГААР БҮЛЭГ МЭДЭЭ ТАЙЛАН, ХЯНАЛТ ШАЛГАЛТ**

### **35 дугаар зүйл. Мэдээ материал, үр дүнгийн тайлан**

35.1. Гэрээлэгч хайгуул, ашиглалтын ажлын үр дүнгийн тайлан, анхдагч мэдээ материалыг хуанлийн тухайн жил дууссанаас хойш 90 хоногийн дотор төрийн захиргааны байгууллагад хүлээлгэн өгнө.

35.2. Гэрээлэгч судалгаа, боловсруулалт, тайлал, лабораторийн туршилт, шинжилгээ хийх зорилгоор чулуун дээж, газрын тос, хий, шингэн болон анхдагч мэдээ материалыг төрийн захиргааны байгууллагаас зөвшөөрөл авч, Монгол Улсын хилээр нэвтрүүлнэ.

35.3. Гэрээлэгч Монгол Улсын хилээр нэвтрүүлсэн газрын тос, хий, шингэн, чулуун дээжийн шинжилгээний үр дүн болон чулуун дээж, анхдагч мэдээ материалыг тухайн жилийн ажил дууссанаас хойш 90 хоногийн дотор төрийн захиргааны байгууллагад хүлээлгэн өгнө.

### **36 дугаар зүйл. Санхүүгийн мэдээ тайлан гаргах**

36.1. Гэрээлэгч нь тухайн жилд оруулсан хөрөнгө оруулалт, гаргасан зардал, нөөц ашигласны төлбөр, олборлосон болон борлуулсан газрын тосны хэмжээ, улсын болон орон нутгийн төсөвт төлсөн албан татвар, энэ хуулийн 34 дүгээр зүйлд заасан төлбөр, урамшуулал, үйлчилгээний хөлсний хэмжээг дараа оны нэгдүгээр улиралд багтаан холбогдох төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллагад хүргүүлж, олон нийтийн мэдээллийн хэрэгслээр мэдээлнэ.

36.2. Гэрээлэгч нь тусгай зөвшөөрөлтэй талбайд хийгдэж байгаа газрын тостой холбогдсон бүх үйл ажиллагааг Нягтлан

бодох бүртгэлийн тухай хуулийн дагуу нягтлан бодох бүртгэлд бүрэн тусгаж, тайлагнана.

### **37 дугаар зүйл. Санхүүгийн хяналт шалгалт, баталгаажуулалт**

37.1. Төрийн аудитын байгууллага холбогдох байгууллагатай хамтран гэрээлэгчийн батлагдсан төлөвлөгөө, төсвийн дагуу хийж гүйцэтгэсэн ажил, нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримт, хөрөнгө оруулалтын болон санхүүгийн тайланд жил бүр хяналт шалгалт хийнэ.

37.2. Энэ хуулийн 37.1-д заасан хяналт шалгалтаар гэрээлэгчийн нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхсөн болон нөхөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтыг хянан баталгаажуулна.

37.3. Төрийн аудитын байгууллага хараат бус мэргэжлийн хөндлөнгийн аудитын байгууллагыг сонгон шалгаруулж энэ хуулийн 37.1-д заасан санхүүгийн хяналт шалгалтын ажлыг гүйцэтгүүлж болно.

37.4. Гэрээлэгч хяналт шалгалтын ажилд шаардагдах мэдээ, мэдээлэл, тайлан материалыг бүрэн гаргаж өгнө.

### **ЕСДҮГЭЭР БҮЛЭГ БУСАД ЗҮЙЛ**

### **38 дугаар зүйл. Онц байдал, давагдашгүй хүчин зүйл**

38.1. Монгол Улсын нийт нутаг дэвсгэрт, эсхүл түүний зарим хэсэгт онц байдал зарласан тохиолдолд Засгийн газар гэрээлэгчид ногдох газрын тос, уламжлалт бус газрын тос, барилга байгууламж, техник, тоног төхөөрөмжийг бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн нөхөх олговортойгоор дайчилж болно.

38.2. Монгол Улсад дайны болон дайн бүхий байдал

үүссэн тохиолдолд гэрээлэгчийн тухайн үеийн техник, технологи, үйлдвэрлэл явуулах аюулгүй нөхцөлд тохицуулан олборлолтыг дээд хэмжээнд хүртэл нэмэгдүүлэхийг гэрээлэгчээс шаардаж болно.

38.3. Давагдашгүй хүчин зүйлийн улмаас гэрээлэгчийн үйл ажиллагаа нэг жилээс дээш хугацаагаар saatсан бол төрийн захиргааны төв байгууллага хайгуул, ашиглалтын хугацаан дээр уг хугацааг сунган тооцно.

### **39 дүгээр зүйл. Эд хөрөнгө өмчлөх эрх шилжүүлэх**

39.1. Газрын тос, уламжлалт бус газрын тосны хайгуул, ашиглалтын үйл ажиллагаа явуулах зорилгоор Монгол Улсын нутаг дэвсгэрт оруулж ирсэн гэрээлэгчийн техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, бараа материал, үл хөдлөх хөрөнгийг гэрээний хугацаа дуусгавар болохоос өмнө, эсхүл дуусгавар болсны дараа өмчлөх асуудлыг гэрээнд заасны дагуу шийдвэрлэнэ.

39.2. Энэ хуулийн 39.1-д заасан хөрөнгийг Засгийн газар шилжүүлэн авахаас татгалзсан тохиолдолд гэрээлэгч нь татан буулгалтыг өөрийн зардлаар гүйцэтгэнэ.

### **40 дүгээр зүйл. Эд хөрөнгийн хохирлыг нөхөн төлөх**

40.1. Гэрээлэгч нь хайгуул, ашиглалтын явцад худаг, өвөлжөө, намаржаа, хаваржаа, хувийн болон нийтийн зориуалттай орон байр, бусад барилга байгууламж, түүх, соёлын дурсгалт зүйл зэрэг бусдын өмчлөл, эзэмшлийн эд хөрөнгөд хохирол учруулсан бол хохирлыг нь бүрэн хэмжээгээр нөхөн төлнө.

40.2. Гэрээлэгч энэ хуулийн 40.1-д заасан барилга байгууламж, эд хөрөнгийг шилжүүлэн байрлуулахтай холбоотой зардлыг бүрэн хариуцна.

40.3. Энэ хуулийн 40.1-д заасан эд хөрөнгийн хариуцлагыг

гэрээлэгч биелүүлээгүй тохиолдолд Иргэний хуулийн дагуу хариуцлага хүлээнэ.

#### **41 дүгээр зүйл.Даатгал**

41.1.Гэрээлэгч болон туслан гүйцэтгэгч нь газрын тостой холбогдсон үйл ажиллагаа, эд хөрөнгө, ашиг сонирхлоо Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу Монгол Улсын даатгалын эрх бүхий компаниар даатгуулж болно.

41.2.Монгол Улсын даатгалын эрх бүхий компани нь энэ хуулийн 41.1-д заасан даатгалыг хийхээс татгалзсан тохиолдолд гадаад улсын даатгалын хуулийн этгээдээр даатгуулж болно.

#### **42 дугаар зүйл.Бусад ашигт малтмал илрэх, талбай давхцах**

42.1.Хайгуулын явцад байгалийн хийн агууламж илэрсэн тохиолдолд төрийн захиргааны байгууллагад ажлын гурван өдрийн дотор мэдэгдэх бөгөөд тухайн гэрээлэгчтэй байгалийн хийн талаар тусад нь гэрээ байгуулж болно.

42.2.Гэрээлэгч нь хайгуул, ашиглалтын хугацаанд газрын тос, уламжлалт бус газрын тосноос өөр ашигт малтмал илрүүлбэл төрийн захиргааны байгууллагад 15 хоногийн дотор мэдэгдэх бөгөөд уг ашигт малтмалын хайгуул, ашиглалтын үйл ажиллагаатай холбоотой асуудлыг холбогдох хуулиар зохицуулна.

42.3.Түүхий тос, байгалийн хий, уламжлалт бус газрын тосны болон ашигт малтмалын хайгуул, ашиглалтын үйл ажиллагаа нь давхацсан тохиолдолд тусгай зөвшөөрөл эзэмшигчид харилцан гэрээ байгуулж, бие биенийхээ үйл ажиллагаанд саад учруулахгүйгээр ажиллана.

42.4.Энэ хуулийн 42.3-т зааснаар ажиллах боломжгүй бол уг асуудлыг энэ хуулийн 7.1.10-т заасны дагуу шийдвэрлэнэ.

42.5. Засгийн газар энэ хуулийн 42.4-т зааснаар шийдвэрлэхдээ аль нэг талын үйл ажиллагааг бүрэн зогсооход хүрвэл тусгай зөвшөөрөл эзэмшигчийн хайгуул, ашиглалтын үед гарсан бүх зардлыг тусгай зөвшөөрөл авсан тал нь нөхөн төлнө.

#### **43 дугаар зүйл. Маргаан хянан шийдвэрлэх**

43.1. Газрын тостой холбогдсон үйл ажиллагааны явцад үүсэх эд хөрөнгийн болон бусад маргааныг төрийн захиргааны байгууллага, гэрээлэгч хэлэлцээрийн журмаар шийдвэрлэж чадаагүй тохиолдолд гомдлоо арбитрын хэлэлцээртэй бол арбитрын журмаар, бусад тохиолдолд шүүхэд гаргаж болно.

*/Энэ хэсэгт 2017 оны 1 дүгээр сарын 26-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан/*

#### **44 дүгээр зүйл. Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага**

44.1. Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

44.2. Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

44.3. Эрүүгийн хуульд заасан хариуцлага хүлээсэн, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлагыг өмнө нь хоёр удаа хүлээсэн бол тусгай зөвшөөрлийг хүчингүй болгож, тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээд, түүний гүйцэтгэх удирдлага, төлөөлөн удирдах зөвлөл, түүнтэй адилтгах байгууллагын гишүүдийн үүсгэн байгуулсан буюу хувь нийлүүлсэн хуулийн этгээдэд тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосноос хойш таван жилийн хугацаанд дахин хайгуул, ашиглалтын тусгай зөвшөөрөл олгохгүй.

*/Энэ зүйлийг 2015 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/*

#### **45 дугаар зүйл.Хууль хүчин төгөлдөр болох**

45.1. Энэ хуулийг дагаж мөрдөхөөс өмнө буюу 1991 оны 01 дүгээр сарын 18-ны өдөр батлагдсан Газрын тосны тухай хуулийн дагуу байгуулсан гэрээнд энэ хуулийн 17.3.1, 17.3.6-17.3.11, 30.2, 30.4, 32.2, 32.3, 33.1, 33.2-т заасан төлбөр, зардал, өртөг нөхөлт, бүтээгдэхүүн хуваалтыг тухайн гэрээнд заасан хувь, хэмжээгээр зохицуулах ба энэ хуулийн 17.3.2-т заасан нөөц ашигласны төлбөр төлөхгүй байгаа гэрээний тухайд төрийн захиргааны байгууллага гэрээлэгчтэй харилцан тохиролцож уг төлбөрийн хэмжээг тогтооно.

### **МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА 3.ЭНХБОЛД**

**ТӨРӨӨС ГАЗРЫН ТОСНЫ САЛБАРЫГ  
ХӨГЖҮҮЛЭХ ТАЛААР  
БАРИМТЛАХ БОДЛОГО  
/2018-2027/**



## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2018 оны 6 дугаар  
сарын 6-ны өдөр

Дугаар 169

Улаанбаатар  
хот

Төрөөс газрын тосны салбарыг хөгжүүлэх  
талаар баримтлах бодлого  
батлах тухай

Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 8.4, 8.5-д заасныг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Төрөөс газрын тосны салбарыг хөгжүүлэх талаар 2027 он хүртэл баримтлах бодлого"-ыг хавсралт ёсоор баталсугай.

2. "Төрөөс газрын тосны салбарыг хөгжүүлэх талаар баримтлах бодлого"-ыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг батлан хэрэгжүүлж, биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазарт даалгасугай.

3. "Төрөөс газрын тосны салбарыг хөгжүүлэх талаар баримтлах бодлого"-ын хүрээнд авч хэрэгжүүлэх арга хэмжээг Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх жил бүрийн үндсэн чиглэлд, түүнд шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг улсын болон орон нутгийн төсөвт тусгаж, гадаадын зээл, тусгамжид хамруулах, төр, хувийн хөвшлийн түншлэлийн хүрээнд шийдвэрлэх замаар санхүүжүүлж ажиллахыг Сангийн сайд Ч.Хүрэлбаатар, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар болон аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.



Монгол Улсын Ерөнхий сайд

У.ХҮРЭЛСҮХ

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд

Д.СҮМЬЯАБАЗАР

**Засгийн газрын 2018 оны 169 дүгээр  
тогтооолын хавсралт**

**ТӨРӨӨС ГАЗРЫН ТОСНЫ САЛБАРЫГ ХӨГЖҮҮЛЭХ  
ТАЛААР БАРИМТЛАХ БОДЛОГО (2018-2027)**

**Нэг. Ерөнхий мэдээлэл**

Монгол Улсын нутаг дэвсгэрт 2017 оны байдлаар 18 талбайд газрын тос, уламжлалт бус газрын тосны эрлийн гэрээ (газрын тосны 10, нүүрсний давхаргын метан хийн 5, шатдаг занарын 3), 25 талбай (газрын тосны хайгуулын 22, ашиглалтын 3)-д бүтээгдэхүүн хуваах гэрээ (БХГ)-ний дагуу газрын тосны хайгуул, ашиглалтын үйл ажиллагаа явуулж байна.

Өнгөрсөн хугацаанд 391,000 км<sup>2</sup> талбайд хүндийн хүчний судалгаа, 33494 туш.км талбайд хоёр хэмжээст, 6274 км<sup>2</sup> талбайд гурван хэмжээст чичирхийллийн судалгаа хийж, 1534 цооног өрөмдсөн.

Газрын тосны эрэл, хайгуулын ажлын үр дунд 332.6 сая тонн газрын тосны баталгаат нөөц, 43.2 сая тонн ашиглалтын баталгаат нөөцийг тогтоож, Монгол Улсын ашигт малтмалын нөөцийн нэгдсэн санд бүртгэсэн. 1996-2017 онуудад 49.2 сая баррель (6.6 сая тонн) газрын тос олборлон экспортолж, улсын төсөвт 1.3 их наяд төгрөг төвлөрүүлсэн байна.

Улсын Их Хурлын 2016 оны 45 дугаар тогтооолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 2.70-д “Газрын тосны олборлолтыг тогтвортой нэмэгдүүлэн, газрын тос боловсруулах үйлдвэр байгуулна” гэсэн зорилт дэвшүүлсэн. Энэхүү зорилтын хүрээнд Засгийн газрын 2017 оны 92 дугаар тогтооолоор газрын тос боловсруулах үйлдвэр барих төслийг

хэрэгжүүлэх үүрэг бүхий “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” төрийн өмчит ХХК-ийг байгуулж, улмаар жилд 1.5 сая тонн газрын тос боловсруулах хүчин чадалтай үйлдвэр барих нарийвчилсан техник эдийн засгийн үндэслэлийг боловсруулаад байна.

Монгол Улсын газрын тосны олборлолтын хэмжээ 2016 онд 1.1 сая тонн, 2017 онд 960.0 мянган тонн байсан, цаашид 1.0 сая тонн орчим байх төлөвтэй байна. Газрын тос боловсруулах үйлдвэрийг түүхий эдээр тогтвортой хангахын тулд газрын тосны эрэл, хайгуулыг эрчимжүүлж нөөцийг өсгөх, олборлолтыг нэмэгдүүлэх шаардлагатай байна.

Монгол Улс газрын тосны бүтээгдэхүүний дотоодын хэрэглээгээ хангах боловсруулах үйлдвэр байхгүйн улмаас ОХУ, БНХАУ, БНСУ зэрэг орнуудаас 100 хувь импортоор шатахууны хэрэгцээгээ хангаж байгаа бөгөөд жилд ойролцоогоор 1.3 сая тонн шатахуун импортолж байна.

Манай улсын хэмжээнд шатахууны хэрэглээ жилээс жилд өсч, 2020 онд 1.6 сая тонн, 2022 онд 1.9 сая тонн, 2027 онд 2.4 сая тонн болох төлөвтэй байна. Шатахууны импортын хэмжээг төрлөөр нь авч үзэхэд, сүүлийн 10 жилд А-80 автобензиний хэрэглээ тогтмол буурч байгаа бол АИ-92, АИ-95 автобензиний импорт тогтмол өсч, харин дизелийн түлшний импортын өсөлт, бууралт нь уул уурхайн салбарын үйл ажиллагаатай уялдан хэлбэлзэлтэй байгаа ч цаашид урт хугацаанд мөн нэмэгдэх хандлагатай байна.

Манай улсын шатахууны хангамж гадаад эх үүсвэрээс бүрэн хамааралтай байгаа өнөө үед газрын тосны дэлхийн үнийн хэлбэлзэл, нийлүүлэлт, валютын ханшны өөрчлөлтөөс шалтгаалан шатахууны хомсдол, бөөний болон жижиглэнгийн үнийн савалгаа үүсэх магадлалтай бөгөөд энэ нь манай улсын эдийн засгийн тогтвортой байдалд сөргөөр нөлөөлөх хандлагатай байдаг.

Монгол Улсын Засгийн газар, Олон Улсын Валютын сантай хамтран хэрэгжүүлж байгаа “Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр”-ийн хүрээнд автобензин, дизелийн тулшний онцгой албан татварын хувь хэмжээг үе шаттайгаар нэмэгдүүлэхээр тохирсон. Энэ нь шатахууны жижиглэнгийн үнэ өсөх гол хүчин зүйл болж байгаа ч хэрэглэгчдэд нийлүүлж байгаа газрын тосны бүтээгдэхүүний жижиглэнгийн үнийг тогтвортой байлгах зорилгоор Засгийн газрын шийдвэрээр онцгой албан татварт өөрчлөлт оруулах, татварын хугацааг сунгах болон аж ахуйн нэгжүүд шатахууны нөөц бүрдүүлэх зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлж байна.

Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 2.17.6-д “Шатахуун импортлох, үйлдвэрлэх, хадгалах, бөөн болон жижиглэнгээр борлуулах үеийн чанарын хяналтын тогтолцоог сайжруулах”-аар, “Агаар, орчны бохирдлыг бууруулах Үндэсний хөтөлбөр”-ийн 4.3.2-т “Евро-5 стандартад нийцсэн чанарын шаардлага хангасан шатахууны импорт, хэрэглээг дэмжих, стандартын шаардлагад нийцээгүй шатахууныг импортоор оруулах, хэрэглэхийг үе шаттайгаар хориглох, чанарын хяналтын тогтолцоог сайжруулах”-аар, тус хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 3.2.2-т “Стандартын шаардлагад нийцээгүй шатахууны импортод хяналт тавих, төрийн өмчит итгэмжлэгдсэн лабораторийг бий болгох”-оор тус тус заасан. Иймд газрын тосны бүтээгдэхүүний чанарын хяналтын улсын лабораторийг байгуулж, үйл ажиллагааг нь тогтмолжуулах, түүнд шаардагдах төсөв, хөрөнгийн асуудлыг шийдвэрлэх шаардлагатай байна.

Монгол Улсын хэмжээнд газрын тосны бүтээгдэхүүний чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллагын нийт 97 агуулах, 1252 шатахуун түгээх станц, шингэрүүлсэн шатдаг хий цэнэглэх 10 станц (агуулах),

автомашин хийгээр цэнэглэх 78 станцаар дамжуулан бөөний болон жижиглэнгийн худалдаа үйлчилгээ үзүүлж байна.

Түүнчлэн сүүлийн үед шингэрүүлсэн шатдаг хийн хэрэглээ манай улсад ихээхэн нэмэгдэж, ОХУ, БНСУ, БНХАУ-аас импортоор авч байна. Үнээс гадна шингэрүүлсэн шатдаг хийгээс бусад шатдаг хийн барилга байгууламжууд баригдаж, хэрэглээнд нэвтэрч эхлээд байгаа тул холбогдох хууль, эрх зүйн орчинг боловсронгуй болгож, хийн тоног төхөөрөмж, түүнтэй харьцах аюулгүй ажиллагааны дүрэм, журам боловсруулах шаардлагатай байна.

Мөн “Төрөөс газрын тосны салбарт 2017 он хүртэл баримтлах бодлого”-ын залгамж чанарыг хадгалан энэ салбарын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, хүний нөөц, үндэсний ажиллах хүчийг чадавхжуулах, мэргэшүүлэх зорилгоор дээр дурдсан бусад үндэслэл, нөхцөл байдлыг харгалзан үзэж газрын тосны салбарын бодлогыг шинээр боловсруулан батлуулах шаардлага тулгараад байна.

## **Хоёр. Бодлогын зорилго, зорилт**

### **2.1. Бодлогын зорилго**

Төрөөс газрын тосны салбарыг хөгжүүлэх талаар баримтлах бодлого (цаашид “бодлого” гэх)-ын зорилго нь Монгол Улсын газрын тосны салбарт эрэл, хайгуулын ажлыг эрчимжүүлэх, нөөцийг өсгөх, олборлолтыг нэмэгдүүлэх, газрын тос боловсруулах үйлдвэрийг байгуулах, газрын тосны бүтээгдэхүүний хэрэгцээг тогтвортой хангахад оршино.

### **2.2. Бодлогын зорилтууд**

2.2.1. газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуул, ашиглалтыг эрчимжүүлэх;

2.2.2. газрын тос боловсруулах үйлдвэрийг байгуулах,

газрын тосны бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг хөгжүүлэх;

2.2.3. газрын тосны бүтээгдэхүүнээр хэрэглэгчийг тогтвортой хангах, чанарын хяналтын тогтолцоог сайжруулах;

2.2.4. салбарын хүний нөөц, ажиллах хүч бэлтгэх, мэргэшүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх;

2.2.5. газрын тосны салбарын үйл ажиллагааны үед байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, ногоон хөгжил, орон нутгийн хөгжлийг дэмжих;

2.2.6. газрын тосны төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компани байгуулж хөгжүүлэх.

### 2.3. Бодлогын зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа

2.3.1. Газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуул, ашиглалтыг эрчимжүүлэх чиглэлээр:

2.3.1.1. газрын тос, уламжлалт бус газрын тос эрэх, хайх, ашиглах үйл ажиллагааг бүтээгдэхүүн хуваах гэрээ, татвар-роялти, бусад гэрээний зарчмаар явуулах;

2.3.1.2. газрын тосны хайгуул, ашиглалтын үйл ажиллагаан дахь төрийн захиргааны болон нутгийн захиргааны байгууллагуудын уялдаа холбоог сайжруулах;

2.3.1.3. газрын тостой холбогдсон үйл ажиллагааны хөрөнгө оруулалтыг дэмжих, хамгаалах;

2.3.1.4. салбарын үйл ажиллагааны стандарт, дүрэм, журмыг боловсронгуй болгох, шинээр боловсруулах, сурталчлан таниулах арга хэмжээг зохион байгуулах;

2.3.1.5. газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуулын ажил гүйцэтгэж, хэтийн төлвийг тодорхойлох;

2.3.1.6. газрын тосны орд ашиглалтыг эрчимжүүлж, олборлолтыг боломжит хэмжээгээр нэмэгдүүлэх, газрын

тосны ордын дэд бүтцийг хөгжүүлэх, тээвэрлэлтийн менежментийг боловсронгуй болгох;

2.3.1.7. Монгол Улсын нутаг дэвсгэрээс олборлосон газрын тосыг дотоодын боловсруулах үйлдвэрт тэргүүн ээлжинд нийлүүлэх.

2.3.2. Газрын тос боловсруулах үйлдвэрийг байгуулах, газрын тосны бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг хөгжүүлэх чиглэлээр:

2.3.2.1. Монгол Улсын нутаг дэвсгэрээс олборлож байгаа газрын тосыг боловсруулах төрийн өмчит үйлдвэрийг ашиглалтад оруулах;

2.3.2.2. газрын тосны бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг татварын таатай бодлогоор дэмжих;

2.3.2.3. газрын тосны тээвэрлэлт, дамжуулах хоолойн судалгааг хийх;

2.3.2.4. газрын тос боловсруулах үйлдвэр болон түүхий тос дамжуулах хоолойн барилга байгууламж, техник технологи, тоног төхөөрөмж, тэдгээрийн угсралт, аюулгүй ажиллагаатай холбоотой стандарт, норм, дүрэм, журмыг боловсруулах;

2.3.2.5. олон улсын патенттай технологи ашиглан чанар, стандартын шаардлагад нийцсэн газрын тосны бусад бүтээгдэхүүн үйлдвэрлэх үйлдвэрлэлийг дэмжих;

2.3.2.6. нүүрс боловсруулах, нүүрснээс шингэн түлш гарган авах үйлдвэрлэлийг газрын тосны бүтээгдэхүүний хангамжийн бодлоготой уялдуулах;

2.3.2.7. уламжлалт бус газрын тосны эх үүсвэрээс (нүүрсний давхаргын метан, занар, байгалийн битум, тослог элс г.м) шингэн болон хийн түлш боловсруулах судалгаа,

шинжилгээ, үйлдвэрлэлийг дэмжих.

2.3.3. Газрын тосны бүтээгдэхүүнээр хэрэглэгчийг тогтвортой хангах, чанарын хяналтын тогтолцоог сайжруулах чиглэлээр:

2.3.3.1. чанарын шаардлага хангасан газрын тосны бүтээгдэхүүнээр хэрэглэгчийг тогтвортой хангах;

2.3.3.2. газрын тосны бүтээгдэхүүний улсын болон аж ахуйн нэгжийн нөөц бүрдүүлэх, шатахууны үнийн хэлбэлзлийг зохицуулах зорилгоор Эрсдэлийн сан байгуулах асуудлыг судлан эрх бүхий байгууллагаар шийдвэрлүүлэх;

2.3.3.3. газрын тосны бүтээгдэхүүний үйлдвэрлэл, хадгалалт, тээвэрлэлт, техник ашиглалт, аюулгүй ажиллагаатай холбогдсон стандарт, норм, дүрэм, журмыг боловсронгуй болгох, шинээр боловсруулах, сурталчлан таниулах арга хэмжээг зохион байгуулах;

2.3.3.4. нийлүүлэлтийг тогтвортой хангах талаар газрын тос, газрын тосны бүтээгдэхүүн экспортлогч орнуудтай Засгийн газрын түвшинд тохиролцох, импортын эх үүсвэрийг дотоодын үйлдвэрлэлийн хүчин чадалтай уялдуулах;

2.3.3.5. дэвшилтэт техник технологи, тоног төхөөрөмж нэвтрүүлэх замаар газрын тосны бүтээгдэхүүн түгээх байгууламжийн аюулгүй ажиллагааг хангах;

2.3.3.6. газрын тосны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь дэргэдээ газрын тосны бүтээгдэхүүний чанарын хяналтыг гүйцэтгэх лабораторийг итгэмжлэлийн үндсэн дээр байгуулах;

2.3.3.7. агаарын бохирдлыг бууруулах экологийн цэвэр түлшний хэрэглээг нэмэгдүүлэх зорилгоор шатдаг хийн салбарыг хөгжүүлэх.

2.3.4. Салбарын хүний нөөц, ажиллах хүчийг бэлтгэх, мэргэшүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх чиглэлээр:

2.3.4.1. салбарын хөдөлмөрийн зах зээлийн судалгааны үндсэн дээр үндэсний мэргэжилтэн, мэргэшсэн хүний нөөц, ажиллах хүчийг бэлтгэх, давтан сургах, мэргэшүүлэх;

2.3.4.2. сургалтын урамшууллын хөрөнгийг ахисан шатны болон тодорхой чиглэлээр нарийн мэргэшүүлэх сургалт, судалгаа, шинжилгээ, технологи эзэмших, нутагшуулах чиглэлээр зарцуулах;

2.3.4.3. газрын тосны салбарт үндэсний ажиллах хучний оролцоо, ажил эрхлэлтийг үе шаттайгаар нэмэгдүүлэх.

2.3.5. Газрын тосны салбарын үйл ажиллагааны үед байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, ногоон хөгжил, орон нутгийн хөгжлийг дэмжих чиглэлээр:

2.3.5.1. байгаль орчинд сөрөг нөлөөлөл багатай дэвшилтэт техник, технологи, олон улсын тэргүүн туршлага, стандартыг нэвтрүүлэх, ногоон хөгжлийг дэмжих;

2.3.5.2. газрын тос, уламжлалт бус газрын тос эрэх, хайх, опборлох, ашиглах, хадгалах, тээвэрлэх, борлуулахтай холбоотой үйл ажиллагааг дагасан үйлдвэрлэл, үйлчилгээг хөгжүүлж, дэд бүтцийн бүтээн байгуулалтыг хийх замаар орон нутгийн ажиллах хүч болон худалдан авалтыг нэмэгдүүлж, орон нутгийн хөгжлийг дэмжих;

2.3.5.3. газрын тосны нөөц ашигласны төлбөр болон тусгай зөвшөөрлийн төлбөрийн тодорхой хувийг газрын тосны үйл ажиллагаа явуулж байгаа орон нутагт нь хуваарилах хууль, эрх зүйн орчинг бүрдүүлэх;

2.3.5.4. байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, хөрсний доройтлыг бууруулах үйл ажиллагаанд орчин үеийн дэвшилтэт техник, технологи ашиглах, нэвтрүүлэх,

бохирдуулагч нь холбогдох төлбөрийг төлөх, нөхөн сэргээх зарчмыг хэрэгжүүлэх.

2.3.6. Газрын тосны төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компани байгуулж хөгжүүлэх чиглэлээр:

2.3.6.1. төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компани байгуулж, үйл ажиллагааг нь компанийн засаглалаар хөгжүүлэх;

2.3.6.2. газрын тосны салбарын мэдээлэл, судалгаа, шинжилгээний төвийг олон улсын жишигт нийцүүлэн хөгжүүлэх;

2.3.6.3. газрын тосны хайгуулын үр дүнгийн анхдагч материал боловсруулах, чулуун болон тосны дээжид шинжилгээ хийх, салбарын хэмжээний нэгдсэн тайлан боловсруулах, эрдэм шинжилгээний болон сэдэвчилсэн судалгаа хийх мэдээлэл, судалгаа, шинжилгээний төв байгуулах;

2.3.6.4. олон улсын стандартын шаардлагад нийцсэн газрын тосны салбарын иж бүрэн мэдээллийн цахим сан үүсгэж, баяжуулах.

### **Гурав. Бодлогыг хэрэгжүүлэх үе шат**

3.1. Бодлогыг 2018-2027 онд дараах үе шаттай хэрэгжүүлнэ:

I үе шат: 2018-2021 онд газрын тосны салбарын бодлого, хууль эрх зүйн орчинг боловсронгуй болгож, дэд бүтцийг сайжруулж, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэн, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой газрын тосны компанийг байгуулах ажлыг эхлүүлснээр улсын нийгэм эдийн засагт үзүүлэх үр нөлөө, өрсөлдөх чадвар дээшилнэ.

II үе шат: 2022-2027 онд стратегийн ач холбогдол бүхий газрын тосны салбарт эрэл, хайгуулын ажил эрчимжиж,

газрын тосны нөөц, олборлолт нэмэгдэн боловсруулах үйлдвэр байгуулагдаж, хүний нөөцийн чадавх бэхжиж, газрын тосны бүтээгдэхүүний хэрэгцээг тогтвортой хангах газрын тосны үндэсний аж үйлдвэрийн суурь бий болно.

**Дөрөв. Бодлогын үр нөлөө, бүтээгдэхүүний шалгуур  
үзүүлэлт**

4.1. Бодлогын хэрэгжилтийг үнэлэх шалгуур үзүүлэлтийг дараах байдлаар тогтоож, 2017 оны тоон мэдээллийг суурь үзүүлэлт болгон авч үзнэ.

## Хөгжлийн бодлогын баримт бичгийн шалтуур үзүүлэлт

№	Зорилт	Цагийр үзүүлэлт	Хамжих нөхцөлбөрийн төслийн хувь	Сүрье түвшин	Зорилт түвшин	Мэдээллийн эх сурвалж
1	2.2.1. Газрын тоосын уламжлалт бус таарын тоосын эрэл, хангул, ашиглалттай эрчимжүүлэх	Газрын тоосын хангуйлын тогтолцоогийн үзүүлэлт	22 тагийн салбарыг буцааджүүн хувьных гэрээ байгуулсан байна.	Шинээр 3 тагийн салбарыг буцааджүүн хувьных гэрээ байгуулсан байна.	Шинээр 2 тагийн салбарыг буцааджүүн хувьных гэрээ байгуулсан байна.	Үндэслэлийн хувь, АМГ ТТ-ын статистик мэдээлэл
	Газрын тоосын олонбориотой	сая баррель	7.7	8.8	10.3	Үндэслэлийн хувь, АМГ ТТ-ын статистик мэдээлэл
2	2.2.2. Газрын тоосын боловсролын улдвартайлан байгуулж, газрын тоосын булагчлалын улдвартолгоёотой хөгжүүлэх	2.1 Газрын тоосын булагчлалын улдвартайлан байгуулж, газрын тоосын булагчлалын улдвартолгоёотой хөгжүүлэх	ТЭЗҮ болөвсргүүж байна.	Газрын тоосын боловсролыг чилдэрээр ашиглалтад орсон байна	Дотодын газрын тоосын булагчлалын хоригийн 50% (1.2 сая тн)-дас дошигүйг сангаан байна.	УУХЯ, АМГТ, "Монгол газрын тос боловсруулж уйдвэр" ТӨХХК
	2.2 Нийтиг байгалийн хий болон бусад давхар булагчлалын улдвартайлан байгуулж, газрын тоосын булагчлалын улдвартолгоёотой хөгжүүлэх	сая.м³	ТЭЗҮ болөвсргүүж байгуулж, газрын тоосын булагчлалын улдвартайлан байгуулж, газрын тоосын булагчлалын улдвартолгоёотой хөгжүүлэх	Нүүрсээс чинилг байгалийн хий улдвартайлан байгуулж, газрын тоосын булагчлалын улдвартайлан байгуулж, газрын тоосын булагчлалын улдвартолгоёотой хөгжүүлэх	Нийтиг байгалийн хийтээр дотодын хориг цэг бүрэн хангасан байна.	УУХЯ, "Нүүрсээс чинилг байгалийн хий улдвартайлан байгуулж, газрын тоосын булагчлалын улдвартайлан байгуулж, газрын тоосын булагчлалын улдвартолгоёотой хөгжүүлэх
3	2.2.3. Газрын тоосын булагчлалын тогтолцоогийн хангах, чанарын хонхалтын тогтолцоогийн сайжруулах	Газрын тоосын булагчлалын тогтолцоогийн хангах, чанарын хонхалтын тогтолцоогийн сайжруулах	сая.тн	1.5	1.9	АМГ ТТ, ГЕГ

**ГАЗРЫН ТОСНЫ ТУХАЙ ХУУЛЬ, ТӨРӨӨС ГАЗРЫН ТОСНЫ САЛБАРЫГ  
ХӨГЖҮҮЛЭХ ТАЛААР БАРИМТЛАХ БОДЛОГО, ХЭРЭГЖҮҮЛЭХ  
АРГА ХЭМЖКЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ /2018-2027/**

	Чандр. экологийн аялалын, н5	хувьвер	7.7	50	80	Удзсийн статистикийн хороо
4	2.2.4. Салбарын хүний нөөц, ажиллах хүчийг багасгах, Мэргашуулж, ажлын Байд намалдаулжүүлэх	Хүний тоо	10000	15000	20000	
	Ажлын байр	орон тоо	6000	9000	12000	
5	2.2.5. Газрын тосны салбартай нийтийн ажиллагааны уед, байгаль орчны хамгаалах, нөхөн сервизэх, нөхөн хөхжил, орон нутгийн хөхжилдийг дэмжих	Байгаль, орчны хамгаалах, нөхөн сервизийн зардал	Хайлуп, ашиглалтын шатанд БХГ-ны засанс Байгаль срчинг хамгаалах ажилтны уийн ажилтгалааны төвлөгөөнд тусгасан зардал хөхрөлийг зарцуулна.	Хайлуп, ашиглалтын шатанд БХГ-ны засанс Байгаль срчинг хамгаалах уийн ажилтгалааны төвлөгөөнд тусгасан зардал хөхрөлийг зарцуулна.	Хайлуп, ашиглалтын шатанд БХГ-ны засанс Байгаль срчинг хамгаалах уийн ажилтгалааны төвлөгөөнд тусгасан зардал хөхрөлийг зарцуулна.	УУХЯЯ БОЛДЖАА, Нийтийн ширэдэлэн багасгах, хөгжүүлэх, хөгжлийг төвлөгөөнд тусгасан зарцуулна.

ГАЗРЫН ТОСНЫ ТУХАЙ ХУУЛЬ, ТӨРӨӨС ГАЗРЫН ТОСНЫ САЛБАРЫГ  
 ХӨГЖҮҮЛЭХ ТАЛААР БАРИМТЛАХ БОДЛОГО, ХЭРЭГЖҮҮЛЭХ  
 АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ /2018-2027/

6	2.2.6 Газрын тосны герийн болон герийн үзүүлэлт, индекси наадамт, судалгаа, шинжилгээний орцох тоотой компани, балтуулж, салбарыг хархуулж	Төрийн болон герийн өмчийн нийтийн мэдээлэл, судалгаа, шинжилгээний төслийн төслийг хэрээндэж санна шинжилгээ	Мэдээлэл, судалгаа, шинжилгээний төслийн төслийг хэрээндэж санна шинжилгээ	<ul style="list-style-type: none"> <li>-Хувь хүн болон компанийн чөлөөнд бүртгэлтэй тоог төхөөрөмжийг туслахад төслийг давсан компанийн болго;</li> <li>-Лагутын болон тосны хийдэг дээжийн шинжилгээ хийдэг болсон байх.</li> <li>-Нийдсээг тайлан болонсруулж, эрээм шинжилгээний якин хийсэн байх.</li> <li>-Сэдэвчилсэн судалгаа хийсэн байх;</li> <li>-Эрээм шинжилгээний ажилтантай болсон байх.</li> </ul>	<p>УУХЯА АМГТГ “МТБУ” ТӨХКК</p>
---	--	---	--	---	-------------------------------------

**Тав. Бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд  
шаардагдах хөрөнгийн хэмжээ, санхүүжилтийн эх  
үүсвэр**

5.1. Газрын тосны салбарыг хөгжүүлэх талаар төрөөс баримтлах бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээг дараах эх үүсвэрээс санхүүжүүлнэ:

- 5.1.1. улсын төсөв;
- 5.1.2. гадаадын зээл, тусламж;
- 5.1.3. гадаад, дотоодын хөрөнгө оруулалт;
- 5.1.4. бусад эх үүсвэр.

**Зургаа. Бодлогын хэрэгжилтэд хийх хяналт-шинжилгээ,  
үнэлгээ**

6.1. Бодлогын хэрэгжилтэд хоёр жил тутам хяналт-шинжилгээ, үнэлгээг газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хийж, дөрвөн жил тутам хөндлөнгийн үнэлгээ хийлгэх ажлыг зохион байгуулж, дүнг Засгийн газрын хуралдаанд оруулж хэлэлцүүлнэ.

—оОо—

**ТӨРӨӨС ГАЗРЫН ТОСНЫ САЛБАРЫГ  
ХӨГЖҮҮЛЭХ ТАЛААР БАРИМТЛАХ  
БОДЛОГЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА  
ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ  
/2018-2027/**



МОНГОЛ УЛСЫН  
УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН САЙДЫН ТУШААЛ

2019 оны 08 сарын 08 өдөр

Дугаар A/163


Улаанбаатар хот

Төрөөс газрын тосны салбарыг хөгжүүлэх  
талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх 2018-2027 оны  
үйл ажиллагааны төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг,  
